



ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Г Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлыг зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59.4, 60.1 дэхь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 2.1 дэхь заалт, Техник импорт ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 02-р сарын 26-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн

“Техник импорт” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02-р сарын 26-ны өдрийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2024 оны 04-р сарын 16-ний өдрийн 16.00 цагт Баянгол дүүрэг, 5-р хороо, Энхтайваны өргөн чөлөө-125, Техник импорт ХК-ийн “Хурлын танхим”-д хуралдуулсугай.
2. Техник импорт ХК-ийн 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар лараахь асуудлуудыг хэлэлцэхээр тогтоосугай. Үүнд:
 - 2023 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ын гаргасан дүгнэлт
 - 2023 оны компанийн жилийн үйл ажиллагааны тайлан, ногдол ашгийн тайлан
 - 2024 оны компанийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө
 - 2023 оны компанийн ТУЗ-ын үйл ажиллагааны тайлан, 2024 оны ТУЗ-ын төсөв
 - 2024 оны компанийн ТУЗ-ын ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
3. “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 2.5-д заасны дагуу бүртгэлийн өдрийг 2024 оны 03-р сарын 18-ны өдрөөр тасалбар болгохоор тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг ҮЦТХТ-өөс 2024 оны 03 сарын 18-ны өдөр (бүртгэх өдөр)-өөр тасалбар болгон гаргасан хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг үндэслэн тогтоосугай.
5. Компанийн 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04-р сарын 16-ны өдөр хуралдуулахаар шийдвэрлэсэнтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн хурлын зар /Хавсралт1/-ыг Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат



ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

_____ оны _____ сарын _____ өдөр

Дугаар _____

Улаанбаатар хот

компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-д заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд хүргэсүгэй. _____ 7

6. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хурлыг зохих журмын дагуу явуулахыг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
7. 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Дашдондог овогтой Ганцэцэгийг томилсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссыг дараахь бүрэлдэхүүнтэй томилсугай.
Тооллогын комиссын дарга Б.Лхамсүрэн
Тооллогын комиссын гишүүн Д.Мөнхтуяа
9. Компанийн тухай хуулийн 67.3, 67.4-т заасан эрх, үүргийг хэрэгжүүлж санал хураалтын дүнг үнэн, зөв гаргаж хариуцлагатай ажиллахыг Тооллогын комисст үүрэг болгосугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь Хавсралт2-т заасан бичиг баримттай танилцах бүрэн эрхтэй болохыг дурьдсугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлаар санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2024 оны 04-р сарын 15-ны өдрийн 18 цагаар тасалбар болгосугай.
12. Хурал хуралдуулах шийдвэрийг гаргаснаас хойш ажлын 3 хоногийн дотор Техник импорт ХК-ийн ТУЗ-ын хурлын тэмдэглэл, тогтоол, хавсралт материалууд, СЗХ-ноос баталсан "Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл" маягтын хамт Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн бирж ТӨХК-д тус тус хүргүүлэхийг ТУЗ-ын нарийн бичгийн дарга О.Бүжинлхамд үүрэг болгосугай.

ТУЗ-ЫН ДАРГА
Т.ТУНГАЛАГ

T. Tungalag